



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/70

Мандалговь

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг
сунгах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгахыг Боловсрол, соёл, урлагийн газар (А.Мөнхтуяа)-т зөвшөөрсүгэй.

3. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаад байнгын хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газар (А.Мөнхтуяа)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210175